Улсын ерөнхий прокурорын 2026 оны
06 дугаар сарын 09-ний өдрийн
А/95 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

√	Прокурорын байгууллагын бүтцийг шинэчлэн батлалсан

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:	Төрийн албаны тухай хууль 2017-12-07
Дагаж мөрдөх огноо:	2019-01-01
Албан тушаалын тодорхойлолтыг батлалсан огноо:	2026-06-09

Байгууллагын нэр:	Нэгжийн нэр:
Улсын ерөнхий прокурорын газар	Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар
Албан тушаалын нэр:	**Албан тушаалын ангилал, зэрэглэл:**
Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Цахим хөгжил, мэдээллийн технологийн газрын дарга	Төрийн тусгай
Ажлын цаг:	**Ажлын байрны албан ёсны байршил:**
Ажлын өдрийн 8 цаг	Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу, Хуульчдын гудамж 15/1
Хөдөлмөрийн нөхцөл:	**Онцгой нөхцөл:**
Хэвийн	Хамаарахгүй

II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:
Төрийн цахим засаглалын бодлоготой уялдуулан прокурорын байгууллагын цахим хөгжлийн бодлого, чиглэлийг тодорхойлж, хэрэгжилтийг зохион байгуулах, мэдээллийн нэгдсэн сангийн хөгжүүлэлт, сүлжээний дэд бүтцийн хэвийн үйл ажиллагаа, нууцлал, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах.

Албан тушаалын зорилт:
1.Төрийн цахим засаглалын бодлоготой уялдуулан прокурорын байгууллагын цахим хөгжлийн бодлого, чиглэлийг тодорхойлж, хэрэгжилтийг зохион байгуулах;
2.Прокурорын байгууллагын мэдээллийн сан, систем, сүлжээ, тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагааг хангах, техникийн дэд бүтцийг шинэчлэх, засварлах, өргөтгөх, дэвшилтэт шийдлүүдийг нэвтрүүлэх;
3.Байгууллагын үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшилтэт шийдлийг нэвтрүүлэх, цахим систем, программ хангамжийг хөгжүүлэх, интеграци хийх, мэдээллийн санг удирдах, систем хэрэглэгчид мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх;
4.Газар, хэлтсийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, гүйцэтгэлд хяналт тавих.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.1.Прокурорын байгууллагын мэдээллийн аюулгүй байдал, цахим хөгжлийн бодлого, чиглэлийг тодорхойлж, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлт, үр дүнг үнэлж дүгнэх.	Бодлого чиглэлийг тодорхойлж, үр дүнг тооцсон байна.	Г, Х
	1.2.Прокурорын байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэгдэх программ хангамж, системийн шинэчлэл, хөгжүүлэлтийг төлөвлөж, хэрэгжилтийг зохион байгуулах.	Ажлыг төлөвлөж, хэрэгжүүлэх арга хэмжээ авсан байна.	Г, Х
	1.3.Системийн хөгжүүлэлт хийх саналыг судалж шийдвэрлэх, цахим систем, мэдээллийн сангийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, санал, дүгнэлт боловсруулах.	Саналыг шийдвэрлэж, хяналт-шинжилгээ хийсэн байна.	Х
	1.4.Цахим системийн бүртгэл, эрхийн удирдлагын хэрэгжилтэд хяналт тавьж, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангуулан, зөрчлөөс урьдчилан сэргийлэх.	Хяналт тавьж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан байна.	Х
	1.5.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний төсөлд санал боловсруулж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах.	Төлөвлөлтийг оновчтой хийж, биелэлтийг хангуулсан байна.	Х
	1.6.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, Үндсэн хуулийн цэц, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад байгууллагаас ирүүлсэн хууль, дүрэм, журам, зааврын төсөлтэй танилцаж санал өгөх, мөн ирүүлсэн мэдээлэл, албан бичигт тайлбар хийх, зохион байгуулалтын шаардлагатай бусад арга хэмжээг авах.	Үндэслэл бүхий санал, тайлбар боловсруулсан байна.	Г, Х
	1.7.Хариуцсан ажлын чиглэлээр Улсын ерөнхий прокурорын дэргэдэх зөвлөлийн хуралдаанд асуудал хэлэлцүүлэн, шийдвэрлүүлэх.	Шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Г

	1.8.Мэдээллийн технологийн талаар төрөөс хэрэгжүүлж буй бодлого, чиглэлийг байгууллагын үйл ажиллагаанд нийцүүлж, бусад байгууллагатай хамтран ажиллах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх.	Хамтран ажиллаж, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.	Г, Х
	1.9.Мэдээллийн технологийн үйл ажиллагааг сайжруулж, хэвийн ажиллах нөхцөлийг ханган, шаардагдах төсөв, хөрөнгийн тооцооллыг гаргаж шийдвэрлүүлэх.	Төсөв, хөрөнгийн тооцооллыг гаргаж, шийдвэрлүүлсэн байна.	Г, Х
	1.10.Цахим мэдээлэл ашиглахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг прокурорын байгууллагын хэмжээнд хангуулж, хэрэгжилтэд хяналт тавих.	Хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авсан байна.	Х, Ш
	1.11.Нээлттэй мэдээлэл хүссэн хүсэлтийн дагуу цахим бүртгэлийн нэгдсэн системээс холбогдох тоон судалгааг гаргах.	Нэгдсэн системээс холбогдох тоон судалгааг гаргасан байна.	Х, Ш
	1.12.Зохион байгуулалтын бүтцийн нэгжээс ирүүлсэн хүсэлтийн дагуу статистик тоон мэдээ, судалгаа гаргах.	Статистик тоон мэдээ, судалгааг гаргасан байна.	Х, Ш
	1.13.Хөгжүүлсэн программ хангамжийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх ажлыг удирдан зохион байгуулах.	Үйл ажиллагаанд нэвтрүүлэх арга хэмжээ авсан байна.	Х, Ш
	1.14.Систем хэрэглэгчдэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх.	Мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлсэн байна.	Х, Ш
	1.15.Прокурор, ажилтнуудад мэдээллийн технологийн мэдлэг, чадварыг хөгжүүлэх чиглэлээр ажил, арга хэмжээ зохион байгуулах	Ажил, арга хэмжээ зохион байгуулсан байна.	Х, Ш
	1.16.Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний хэрэгжилтийн талаар прокурорын байгууллагаас хүргүүлж буй тайлан, мэдээ, мэдээллийг боловсруулах.	Холбогдох мэдээллийг үндэслэл бүхий боловсруулсан байна.	Г, Х
	1.17.Олон улсын гэрээ, олон улсын байгууллагын зөвлөмжийн хэрэгжилтийн тайлангийн хуралд оролцох, Засгийн газраас баталсан Ажлын хэсэгт прокурорын байгууллагыг төлөөлөх.	Прокурорын байгууллагын төлөөллийг хэрэгжүүлсэн байна.	Г
	1.18.Нэгж прокурорын газарт хугацаатай үүрэг, даалгавар өгч, биелэлтэд хяналт тавих.	Үндэслэл бүхий үүрэг даалгавар өгч, үр дүнг тооцсон байна.	Х, Ш
	1.19.Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нараас өгсөн үүргийг хэрэгжүүлж, хариуцсан чиг үүрэгтэй холбоотой мэдээллээр хангах.	Үүрэг, даалгаврыг хэрэгжүүлж, мэдээллээр хангасан байна.	Г

	1.20.Хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан заавар, журам, Улсын ерөнхий прокурорын тушаалаар хариуцуулсан чиг үүргийг хэрэгжүүлэх.	Хууль, заавар, журамд заасан чиг үүрэг хэрэгжсэн байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	2.1.Байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах	Баримт бичгийн хэрэгжилтийг хангуулсан байна.	Х, Ш
	2.2.Мэдээллийн сан, мэдээллийн системийн үйл ажиллагааг хортой кодоос хамгаалах, цахим халдлага илрүүлэх, болзошгүй аюул болон эмзэг байдал, эрсдэлийг тодорхойлж нууцлал, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах.	Аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авсан байна.	Х, Ш
	2.3.Мэдээллийн сан, мэдээллийн системийн үйл ажиллагаа, сүлжээний нууцлал, аюулгүй байдал алдагдсан гэж үзвэл хариу арга хэмжээг шуурхай авч, нөхөн сэргээх.	Шуурхай арга хэмжээ авсан байна.	Х, Ш
	2.4.Байгууллагын нэгдсэн сүлжээний архитектур, топологи, өргөтгөлийг төлөвлөх, хэвийн ажиллагааг хангах, тасралт саатлын үед яаралтай хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	Хариу арга хэмжээ авсан байна.	Х, Ш
	2.5.Байгууллагын нэгдсэн сангийн техник хангамжийн бэлэн байдал хангах, хэвийн үйл ажиллагааг хариуцах, өргөтгөл, шинэчлэлтийг тогтмол хийх.	Бэлэн байдлыг хангаж, өргөтгөл, шинэчлэл хийгдсэн байна	Х, Ш
	2.6.Улсын ерөнхий прокурорын газраас зохион байгуулах уулзалт, хурал, зөвлөгөөний техникийн хэвийн үйл ажиллагааг хангуулах.	Техникийн хэвийн үйл ажиллагаа хангагдсан байна.	Х, Ш
	2.7.Аюулгүй байдал хариуцсан бүтцийн нэгжтэй хамтран хяналтын камерын нэгдсэн системийн хэвийн үйл ажиллагааг хангуулах.	Хяналтын камерын хэвийн үйл ажиллагаа хангагдсан байна.	Х, Ш
	2.8.Тоон гарын үсгийн төхөөрөмж олгох, сертификат шинээр суулгах, шинэчлэх ажлыг удирдан зохион байгуулах.	Ажлыг удирдан зохион байгуулсан байна.	Х, Ш
	2.9.Албаны цахим шуудангийн хаяг ашиглах эрхийг олгох, түүний тасралтгүй ажиллах нөхцөлийг хангах ажлыг удирдан зохион байгуулах.	Ажлыг удирдан зохион байгуулсан байна.	Х, Ш
	2.10.Тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтлийг засварлах, тохиргоо хийх ажлыг зохион байгуулах.	Зохион байгуулалтын арга хэмжээ авсан байна.	Х, Ш
	2.11.Прокурорын байгууллагын цахим хуудасны техникийн тасралтгүй ажиллагааг хангуулах.	Тасралтгүй ажиллагааг хангах арга хэмжээг авсан байна.	Х,Ш

3 дугаар зорилтын хүрээнд	3.1.Байгууллагын цахим хөгжил, инноваци технологи нэвтрүүлэлтийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах.	Баримт бичгийн хэрэгжилтийг хангуулсан байна.	Х, Ш
	3.2.Системийн шинжилгээ хийж, программ хөгжүүлэлтийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох.	Хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон байна.	Х, Ш
	3.3.Мэдээллийн технологийн дэвшилтэт шийдлүүдийг нэвтрүүлэх, өгөгдлийн сангийн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны загварчлал хийх ажлыг удирдан зохион байгуулах.	Дэвшилтэт шийдлийг нэвтрүүлсэн байна.	Х, Ш
	3.4.Прокурорын хяналтын үйл ажиллагааг автоматжуулах замаар ажлын ачааллыг бууруулахад чиглэсэн ажлыг зохион байгуулах.	Ажил зохион байгуулсан байна.	Х, Ш
	3.5.Төрийн үйлчилгээний системүүдийг байгууллагын үйл ажиллагаанд ашиглах, бусад байгууллагын өгөгдлийн сантай уялдуулах ажлыг удирдан зохион байгуулах.	Интеграцийн тоо өссөн байна	Х, Ш
	3.6.Байгууллагын удирдлага, зохион байгуулалт, дотоод ажил болон хяналтын ажлын мэдээг цахим системээс татах, мэдээний цахим архив үүсгэх.	Цахим архив үүсгэсэн байна.	Х, Ш
	3.7.Цахим системд буруу бүртгэсэн мэдээллийг олж илрүүлэх, мэдээллийг зөвтгүүлэх талаар ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэх.	Мэдээллийг зөвтгөх арга хэмжээ авсан байна.	Х, Ш
4 дүгээр зорилтын хүрээнд	4.1.Газар, хэлтсийн ажлыг уялдуулан зохион байгуулах, прокурор, ажилтныг мэргэжлийн удирдлагаар хангах, ажлын гүйцэтгэлд хяналт тавих.	Ажлын гүйцэтгэл, үр дүнг тооцсон байна.	Х
	4.2.Газрын шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулж, үүрэг даалгаврын биелэлт, үр дүнг тооцох.	Үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулсан байна.	Х, Ш
	4.3.Газрын хэмжээнд шаардлагатай бүртгэл, судалгааг хөтлүүлж, хяналт тавих.	Бүртгэл хөтлөлтөд хяналт тавьсан байна.	Х
	4.4.Хариуцсан ажилтай холбоотой мэдээ, мэдээлэл бэлтгэж, олсн нийтэд хүргэх арга хэмжээ авах.	Мэдээ, мэдээллийг бэлтгэж, олон нийтэд хүргэсэн байна.	Х
	4.5.Газрын чиг үүрэгт хамаарах асуудлаар зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдтэй хамтран ажиллаж, бодлого, зорилтыг уялдуулах.	Ажлын уялдаа холбоог хангасан байна.	Г, Х, Ш
	4.6.Газрын хэмжээнд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг гаргуулж, ажил сайжруулахад чиглэсэн ажил, арга хэмжээг тодорхойлж хэрэгжилтийг хангах.	Тайланд үндэслэн ажил, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	Х, Ш

	4.7.Газар, хэлтсийн прокуроруудын хийх ажлын чиглэл, хариуцах нэгжийн хуваарийг гаргаж, хэрэгжилтэд хяналт тавих.	Газрын чиг үүрэг бүрэн хэрэгжих нөхцөл бүрдсэн байна.	Х
	4.8.Архив, албан хэрэг хөтлөлтийн ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, заавар, журам, стандартын хэрэгжилтийг хангах.	Хэрэгжилтийг хангасан байна.	Г, Х

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	
Мэргэжил	Эрх зүй (0421)	
Мэргэшил	-хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээтэй байх -хуульчийн багц цагийн сургалтад хамрагдсан байх	
Туршлага	Дээд шатны прокуророор 3-аас доошгүй жил, эсхүл Улсын ерөнхий прокурорын газарт ахлах прокуророор ажилласан байх	
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	-газар, хэлтсийн үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэх; -прокурор, ажилтанд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх; -эрсдлийг урьдчилан тооцоолох, гарах арга замыг тодорхойлох, эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэх.
	Дүн шинжилгээ хийх	-мэдээллийг цуглуулж, шалган нягтлах; -шийдвэрийн үр дагавар, эрсдлийг үнэлэх; -судалгааны арга зүйг ашиглан санал, дүгнэлт боловсруулах.
	Асуудал шийдвэрлэх	-хариуцсан ажлын явцад үүссэн асуудал, хүндрэл бэрхшээлийн шалтгаан, нөхцөлийг бодит мэдээлэлд үндэслэн тогтоох; -шийдвэрийн үр дагавар эрсдлийг урьдчилан тооцоолох; -хууль тогтоомжид нийцсэн оновчтой шийдвэр гаргах; -гаргасан шийдвэрийн хариуцлагыг хүлээх.
	Манлайлах	-прокурор, ажилтнуудыг үлгэрлэн манлайлах; -ажлын байрны эерэг орчныг бүрдүүлэх; -шинэ санаачилга болон өөрчлөлтийг дэмжих.
	Багаар ажиллах	-хамтын шийдвэр гаргалтад идэвхтэй оролцох; -хариуцсан ажлыг багийн зорилготой уялдуулан хэрэгжүүлэх; -мэдээллийг нээлттэй хуваалцах; -бусдын санал бодлыг хүндэтгэх.
	Бусад	-баримт бичиг боловсруулах; -хууль хэрэглэх; -ажлын ачааллыг оновчтой төлөвлөж, эрэмбэлэн зохион байгуулах; -албан хэрэгцээнд шаардлагатай мэдээллийн систем, программ хангамжийг ашиглах, мэдээллийг цахим орчинд боловсруулах.

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:
1.Улсын ерөнхий прокурор
2.Улсын ерөнхий прокурорын орлогч

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	Бусад харилцах субъект:
1. Газрын хяналтын прокурор 2. Хэлтсийн дарга, ахлах прокурор 3. Хэлтсийн хяналтын прокурор 4. Газрын референт, туслах ажилтан	1.Нэгж прокурорын газрын прокурор, ажилтан 2.Мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага 3.Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллага

Нийт: 4	4.Шүүх 5.Бусад төрийн байгууллага 6.Иргэн, хуулийн этгээд

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ТУСЛАХ ПРОКУРОР, БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА Н.ЭНХТУЯА 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдөр	Байгууллагын нэр: УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ДЭРГЭДЭХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН Шийдвэрийн огноо: 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Дугаар: 2

Албан тушаалын тодорхойлолт баталсан:

Байгууллагын нэр:
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР
Шийдвэрийн огноо: 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдөр

Дугаар: А/95

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР
ТӨРИЙН ХУУЛЬ ЦАЗЫН
ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ Б.ЖАРГАЛСАЙХАН

2026 оны 06 дугаар сарын 09-ний өдөр